

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2022 оны 8 дугаар сарын 10

Тендер шалгаруулалтын нэр: “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв”-ийн газрын доорх байгууламж, сургалтын төвийн угсралт, заслын ажил

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202207703

“Монголросцветмет” ТӨҮГазар нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв”-ийн газрын доорх байгууламж, сургалтын төвийн угсралт, заслын ажил –ыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **“Тийм”**

Багц №1. Газрын доорх сургалтын штрекийн угсралт заслын ажил

Багц №2. Монголын далд уурхайн сургалтын төвд суралцагчдын хоол бэлтгэлийн өрөөний угсралт, заслын ажил

Багц №3. Газрын доорх энтертэймент штрекийн коридорын шал, агааржуулалтын болон нөөц гарцын угсралт, заслын ажил

Багц №4. Газрын доорх байгууламжуудын инженерын хангамж (халаалтын агаар сэлгэлт, цэвэр, бохир ус, хүчинтэй төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг, холбоо, дохиолол)-ийн ажил

Багц №5. Сургалт, судалгааны төвийн барилгын угсралт, заслын ажил

Багц №6. Газрын доорх VR өрөөний угсралт, заслын ажил

Багц №7. Газрын доорх байгууламжийн агааржуулалтын системийн тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендер нь түүнийг нээснээс 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба багц тус бүрээр төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон ТББ-ийн ТӨХ-д заагдсан үнийн дүнтэй тэнцэхүйц тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2022 оны 9 дүээр сарын 9-ний өдрийн 10:00 цагаас өмнө тендерийн баримт бичигт заасан хэлбэрээр ирүүлэх ба тендерийн нээлтийг мөн өдрийн 10:05 цагт зохион байгуулна.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: “Эрхгүй”

Урьдчилсан худалдан авах ажиллагааны урилга эсэх: “Үгүй”

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс авч болох бөгөөд тендерийн тодруулгыг Захиалагч www.tender.gov.mn хаягаар цахим хэлбэрээр хүлээн авна.

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ